

ТОВЪЁОГ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. ТӨСЛИЙННЭР	3
1.1.1. Ашигт малтмалын дугаар	3
1.1.2. Төсөл хэрэгжүүлэгч	3
1.1.3. Төслийн байршил	3
1.1.4. Ордын нөөцийн тооцоо.....	5
1.1.5. Үйлдвэрлэлийн нөөц	5
1.2. Ил уурхай	5
1.2.1. Уурхайн ажиллах горим	5
1.2.2. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө	6
1.2.3. Ашиглалтын системийн сонголт	6
1.2.4. Ашиглалтын системийн элементүүд	6
1.2.5. Уурхайн талбайг ашиглах дараалал	7
1.3. БУТЛАН, АНГИЛАХ ҮЙЛДВЭР	7
1.3.1. Баяжуулалтын технологи	7
1.3.2. Бүтээгдэхүүний баланс	7
1.3.3. Бутлан ангилах хэсгийн ажиллах горим	8
1.3.4. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн байршил	9
1.4. ДЭДБҮТЭЦ	9
1.4.1. Уурхайн усны хэрэгцээ	9
1.4.2. Уурхайн засвар, техникийн үйлчилгээ	10
1.4.3. Уурхайн барилга байгууламж.....	10
1.4.4. Цахилгаан хангамж	10
1.5. 2021 онд хийгдэх ажлын хэмжээ	10
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	10
2.1. Уур амьсгалын үзүүлэлтүүд	10
2.2. Газрын гадарга, хэвлийн тогтоц, онцлог	11
2.2.1. Геологийн тогтоц, давхрага зүй	11
2.2.2. Гидрогеологи.....	11
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	12
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	12
БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	13
5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13
5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	16
5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	16
5.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө 17	
5.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	17
5.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	17
5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	19
5.8. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	20
5.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	23

5.10. Тухайн жилийн БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь\ 24

ХАВСРАЛТУУД

1. Хяналтын хуудас
2. ААН-ийн гэрчилгээ
3. БОННУ-ний баталгаажсан нүүр
4. Урт нэртэй хуулийн лавлагаа
5. 2022 оны аймгийн дүгнэлт
6. 2023 оны БОМТ -ий хэрэгжилтийн тайлангийн нүүр
7. Барьцаа хөрөнгө төлсөн баримт
8. АМГТГ-ийн баталсан 2023 онд хэрэгжүүлэх уулын ажлын төлөвлөгөөний баталгаажсан нүүр (зарим хавсралт)
9. ТЭЗҮ баталсан тушаал, тэмдэглэл
- 10 .Уулын ажлын дэвсгэр зураг
- 11.2023 онд хэрэгжүүлэх БОМТ-ний файл бүхий СД

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСЛИЙН НЭР

Гөлтгөний ордыг ил аргаар ашиглах

1.1.1 Ашигт малтмалын дугаар

MV-005356, (8=38.31 га)

1.1.2 Төсөл хэрэгжүүлэгч


Төсөл хэрэгжүүлэгч: "Түмэнтал" ХХК,

- Регистрийн дугаар: 5547938;
- Улсын бүртгэлийн дугаар: 9019079096;
- Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, бага тойруу 19 байр 32 тоот Утас: 99099048

1.1.3 Төслийн байршил

MV-005356 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь Монгол улсын засаг захиргааны нэгжийн хувьд Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутаг дэвсгэрт Ширээ уул нэртэй газарт орших Ширээ уул-2 гөлтгөнийн уурхай нь Улаанбаатар хотоос баруун урд зүгт 400 км, Дэлгэрхангай сумын төвөөс баруун урд зүгт 50 км, Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт төмөр замын 7-р зөрлөгийн ойролцоо байршилтай Цементийн үйлдвэрээс баруун урд зүгт 380 км зайд оршино. MV-005356 дугаартай тусгай зөвшөөрөлтэй талбай дараах солбицолд оршино. Үүнд:

1. 104° 20'47.11" 44° 59'14.5"
2. 104° 20'20.11" 44° 59'14.5"
3. 104° 20' 20.11" 44° 59' 35.49"
4. 104° 20'47.11" 44° 59' 35.49"



Зураг: 1 Байршлын тойм зураг.



Зураг 2. Уурхайн талбайн ерөнхий байдал



Зураг 3. Уринш бэлтгэсэн талбай



Зураг 4. Уурхайн карьерийн хана

1.1.4 Ордын нөөцийн тооцоо

Ширээ уул-2 гөлтгөний орд нь геологийн тогтоц, ашигт малтмалын нөөцийн хэмжээгээрээ гөлтгөний ордын нөөцийн ангиллын I бүлгийн 2-р төрөл гэсэн ангилалд хамаарах ба ашигт малтмал агуулсан хурдасны зузаан болон агуулга нь харьцангуй жигд тогтвортой байдаг.

Хүснэгт 1 Ордын геологийн нөөцийн нэгтгэл

д/д	Блокийн Дугаар	Хөрс хуулалт /м3/	Гөлтгөний й ашигт давхарга /м3/	Гөлтгөний й нөөц /тн/	Хөрс ба ашигт давхаргы н харьцаа	Ca8O42H 20
1	В-1	237033.1	401284,3	369181,5	1:1,6	71,24
2	В-2	278191.2	402897,6	370665,7	1:1,4	72,29
3	В-3	299261.4	436040,5	401157,2	1:1,4	78,49
4	В-4	245550	425620	391570,4	1:1,7	76,20
Нийт	1060035.7	1665824,4	1532574,8	1:1,5		74,45

1.1.5. Үйлдвэрлэлийн нөөц

Хаягдал, бохирдлыг тооцсоноор үйлдвэрлэлийн нөөц 41 557.9м3 буюу 38 233.3тн гөлтгөнө олборлохоор төлөвлөсөн байна.

1.2. Ил уурхай

1.2.1. Уурхайн ажиллах горим

Уулын ажлыг нийт 6 сарын хугацаанд явуулах ба уурхай нь 4-р сарын 20-аас эхлэн уурхайн бэлтгэл ажлууд болон хөрс хуулалтын ажлыг эхлүүлж, 11-р сарын 15 хүртэл олборлох болон бутлан ангилах ажиллагааг явуулна.

Уурхай нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулах учир олборлолт явуулах үед тасралтгүй ажиллана. Улсын чанартай баяр ёслолын өдрүүдэд амарна. Харин техник, тоног төхөөрөмжүүдэд үзлэг үйлчилгээ, урсгал засвар хийх хугацааг сард 3 хоног байхаар ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгалаа.

Жилд ажиллах хоног -180 хоног
Уулын ажлын ажлын хоног -165 хоног
Амралт, баяр ёслолын өдрүүд - 7 хоног
Урсгал засвар хийх өдрүүд -14 хоног
Ээлжийн тоо - 1 ээлж
Ээлжинд ажиллах хугацаа - 8 цаг

1.2.2. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

“Ширээ Уул-2” уурхай нь В-1 гэсэн гөлтгөнө агуулсан ашигт давхаргын геологийн болокуудаас 97.8 мян м³ гөлтгөнө агуулсан давхарга олборлож 90.1 мян м³ хөрс хуулж нийт 108.1 мян м³ (90.1 мян м³ х 1.2) сийрэгжсэн хөрсийг гадаад болон дотоод овоолгод хураана.

Хүснэгт 2 Уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Ашиглалтын жил	Ашигт давхарга	Гөлтгөнө	Хөрс хуулалт	Хөрс хуулалтын коэффициент
он	м3	тн	м3	м3/тн
2023	97.8	90	90.1	0.9

1.2.3. Ашиглалтын системийн сонголт

Уурхайн хуулах хөрсний зузаан 2.41 м, олборлох ашигт давхаргын зузаан 4.08 м байна. Шимт хөрсийг утгуурт ачигч ба автосамосвалын хослолоор тээвэрлэж овоолгод буулгана. Уурхайг тээвэртэй дотоод овоолготой ашиглалтын системээр ажиллуулахаар сонголтхийлээ. Хөрс хуулалт болон ашигт давхаргын олборлолтын ажлыг ордын уул геологийн нөхцөлөөс хамааруулан уламжлалт технологи болох экскаватор - автосамосвалын хослолоор гүйцэтгэнэ. Гөлтгөний ашигт давхаргыг экскаватороор мөргөцгөөс өөрөө буулгагчид ачиж бутлан ангилах үйлдвэрийн дэргэдэх уриншуулах талбайд хүргэж, уриншуулах талбайн болон бутлан ангилах үйлдвэрээс гарсан шавар, хаягдлыг уурхайн дотоод овоолгод тээвэрлэнэ.

1.2.4. Ашиглалтын системийн элементүүд

Тус уурхайн ашиглалтын системийн үндсэн элементүүдийг ордын чулуулгийн физик-механикийн шинж чанар, уул-тээврийн тоног төхөөрөмжийн параметр, технологийн схем, уулын ажлыг явуулах аюулгүй ажиллагааны нөхцөл зэргийг харгалзан тогтоов.

Уурхайн хөрс хуулалт болон олборлолтод Hyundai фирмийн 2900LC-7 маркийн экскаватор ажиллана. Доголын налуугийн өнцгийг “Гипроруда”-ийн баримтлалын дагуу 40о - аар сонгож авав.

Доголын ажлын талбайн хамгийн бага өргөнийг тогтоохдоо техник аюулгүйн дүрмийн шаардлагыг хангах хэмжээнд тоног төхөөрөмжийн параметр, аюулгүй ажиллагааны дараах зайнуудыг үндэслэв.

Доголын ирмэгийн нурж болзошгүй аюулгүйн зурвасын өргөн - 2.0 м

Экскаваторын өргөн - 3.4 м

Автомашинны өргөн - 2.5 м зэрэг зайнуудыг хангахаас гадна автосамосвал мухар мөргөцөгт эргэлт хийн буцаж гарах нөхцөлд автосамосвалын эргэлтийн радиус 18.3 м,

доголын аюулгүйн зурвас 3 м хүртэл зай зэрэг аюулгүй ажиллагааны зайнуудыг хангасан болно.

1.2.5. Уурхайн талбайг ашиглах дараалал

Уурхайн талбайн ашиглах дарааллыг гөлтгөнийн ашигт давхаргын тогтоц, уурхайн хил хязгаар дахь хөрс хуулалтын дундаж коэффициентийг баримталж, уулын ажлыг аль болох жигд барьж явуулах, сонгож авсан тоног төхөөрөмжийн жигд ажиллагааг хангах зэрэг үзүүлэлтүүдийг үндэслэн тогтоов. Уурхайг ашиглах дарааллыг жил бүрийн ашиглалтын зургуудад болон уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний зурагт үзүүлсэн болно.

Хүснэгт 3
Ил уурхайн үндсэн хэмжээс

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1.	Ил уурхайн гүн	м	6-7
2.	Ил уурхайн хажуугийн өнцөг	град	50
3.	Хөрсний доголын өндөр	м	2.4-3
4.	олборлолтын доголын өндөр	м	4-4.5
5.	Авто замын өргөн	М	10
6.	Авто замын налууугийн хэмжээ	%	80
7.	Ажлын талбайн өргөн	м	20-30

1.3. БУТЛАН, АНГИЛАХ ҮЙЛДВЭР

1.3.1. Баяжуулалтын технологи

Орд нь говийн бүсэд орших тул ус ашиглах боломжгүй юм. Иймээс тус ордын гөлтгөнийг хуурай аргаар уриншуулан авахад барилгын гөлтгөнө үйлдвэрлэх техникийн шаардлага хангах боломжтой гэж дүгнэлт хийсний дагуу гөлтгөнийн чулууг бутлан, ангилах технологийн 2 хувилбарыг сонгож байна.

1.3.2. Бүтээгдэхүүний баланс

Энэ үйлдвэр нь уриншуулж бэлдсэн 74.4%-ийн гөлтгөний агуулгатай, бүхэллэг < 70 мм, чийг 2.7 хувьтай цементийн үйлвэрийн түүхий эдийг жилд 38.0 мян.тонн, хоногт 503 тонн, цагт 45,25 тонныг бэлдэнэ.

Хүснэгт 4 Бүтээгдэхүүний баланс

№	Үзүүлэлтүүд	Бүтээгдэхүүний жин, тн
1	Нэг цагт үйлдвэрлэх	45.25
2	Хоногт үйлдвэрлэх	503
3	Нэг жилд үйлдвэрлэх	38 000.0

1.3.3. Бутлан ангилах хэсгийн ажиллах горим


Бутлан ангилах хэсгийн ажиллах горимыг захиалагчаас өгсөн техникийн даалгаврын дагуу гөлтгөнө үйлдвэрлэх бутлан ангилах хэсэг нь уурхайн ажиллах горимоор дулааны улиралд 155 хоног ажиллахаар тооцлоо. Бутлан ангилах хэсгийг 10 цагийн үргэлжлэлтэй 1 ээлжээр ажиллуулахаар төлөвлөв.

Тоног төхөөрөмжийн сонголт

Хүснэгт 5 Гөлтгөний үйлдвэрийн бутлалт, шигшилтийн технологийн шаардлага Бутлалт

Бутлалт		
Бутлалтын шат	I	
Бутлуурын төрөл	Хацарт	
Анхдагч гөлтгөний ширхэглэлийн том хэмжээ, мм	300	
Бутлуурын гарах завсрын өргөн, мм	70	
Бутлуурын орох завсрын өргөн, мм	345	
Бүтээмж, тн/цаг	75.2	
Шигшилт		
Шигшилтийн шат	2	
Шигшүүрийн төрөл	Хөдөлгөөнгүй	
Шигших нүхний хэмжээ, мм	300*300	70*70
Шигшилтийн бүтээмж, тн/цаг	50.0	75.2

Хүснэгт 6 Бутлах хэсгийн үндсэн тоногтөхөөрөмжүүдийн техникийн үзүүлэлт

<p>Хацарт бутлуур: Загвар: PE 600*900</p> <ul style="list-style-type: none"> - Хүлээн авах амсрын хэмжээ (мм): 600*900 - Амны хэсгийг нээх, тохируулах боломжтой (мм): 500 - - Хацарт бутлуурын хүчин чадал (тонн/цагт) 56-192 - Хөдөлгүүрийн чадал (KW): 75 75 -Жин (t): 15.5 - Овор хэмжээ(мм): 2536x1877x 2340 	
<p>Туузан дамжуулагч: Загвар: B1000</p> <ul style="list-style-type: none"> - Хөдөлгүүрийн чадал (KW): 7 - Туузны хурд (метр/секунд): 1.2-2.6 - Үйлдвэрлэлийн хүчин чадал /Тонн/цагт/: 100-250 	
<p>Доргилтот тэжээгч: Загвар:GZD 800*1800</p> <ul style="list-style-type: none"> - Урсгал зам (мм): 1800x800 - Тэжээлийн хамгийн том бүхэллэгийн хэмжээ (мм): 400 - Хүчин чадал (тонн/цаг): 30-80 - Цахилгаан чадал (KW): 3-6 - Жин (тонн): 1.55 - Нийт хэмжээ (L*W*H)(mm): 2200x1100x800 	
<p>Торон шигшүүр : Загвар: YA 1842</p>	

<ul style="list-style-type: none"> - Хүчин чадал (тонн/цаг): 10-490 - Тэжээлийн хамгийн том бүхэллэгийн хэмжээ (мм): 200 - Шигшсэн бүхэллэгийн хэмжээ (мм): 6-150 - Шигших торны хэмжээ (м2):7 - Шигших торны тоо :1 	
---	--

1.3.4. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн байршил

Бутлах хэсэг нь 20*6.6м талбай эзэлнэ. Энэ талбайд 300 мм-ийн хөдөлгөөнгүй шигшүүр бүхий 8м3 багтаамжтай хүлээн авах бункер, 620 800*1800 маркийн бутлуурын тэжээгч, засварын ажилд хэрэглэх өргөх төхөөрөмж, хацарт бутлуур, туузан дамжуулагч, 8 м3 багтаамжтай бүтээгдэхүүний бункерээс бүрдэнэ. Бутлагдсан гөлтгөнө туузан дамжуулагчаар дамжин бункерт хийгдэх ба эндээс тээвэрлэгдэнэ. Бутлан, ангилах хэсэгт суурилагдах тоног төхөөрөмжүүдийн цахилгааны хэрэглээг хүснэгт №18-т харууллаа.

Хүснэгт 7 Бутлан, ангилах хэсэгт суурилагдах тоног төхөөрөмжүүдийн цахилгааны зарцуулалт

Тоног төхөөрөмж	Марк	Тоо	Нэгжийн цахилгаан зарцуулалт, кВт	Нийт цахилгаан зарцуулалт, кВт
Тэжээлийн бункер	8м3	1	-	-
Тэжээгүүр	GZD 800x180080	1	5	5
Хацарт бутлуур	PE 600x900	1	75.5	75
Туузан конвейер	B1000	2	7	14
Шигшүүр	YA 1842	1	-	-
Агуулах талбай	2000x2000x200 0	1	-	-
Бүгд		-	8	14.0
Бусад тооцогдоогүй/10%/	-	-	-	9.4
Нийт				103.4

1.4. ДЭД БҮТЭЦ

1.4.1. Уурхайн усны хэрэгцээ

Уурхайн унд ахуйн хэрэглээний усыг худгаас хангана. Уурхайд нийт 25 хүн ажиллана. Нэг ажилчны хоногт буюу ажлын байранд хэрэглэх усны хэрэглээ 175л/хоног байна.

$$25 \text{ хүн} \times 200 \text{ л} = 5000 \text{ литр/хоног}$$

Уурхайн тоосжилттой тэмцэхийн тулд уурхайд БНХАУ-ын HOWO фирмийн 5тн усалгааны машин 1ш байх ба технологийн болон ахуйн усны хэрэглээг тооцсон.

Хүснэгт 8 Технологийн болон ахуйн усны хэрэглээ

Зардлын төрөл	Хэмжих нэгж	2023 он
Технологийн ус		
Гүний усны төлбөр, 1м3 тутамд	төг	1,500
Жилд шаардагдах технологийн ус	м3	14,574.64
Дүн	төг	21,861,960.8
Ахуйн ус		
Гүний усны төлбөр, 1м3 тутамд	төг	1,500
Нийт шаардлагатай ахуйн ус	м3	566.79
Дүн	төг	850,187.4
Нийт дүн:	төг	22,712,148.17

1.4.2. Уурхайн засвар, техникийн үйлчилгээ

Засварын газар нь уурхайн хотхонтой ойр ил талбайд байрлах ба контейнерт гагнуурын аппарат, хийн компрессор, точил, босоо өрөм, багажны цуглуулгатай байна. Энд тоног төхөөрөмжүүдийн техникийн үйлчилгээ ба жижиг засвар, үзлэг хийнэ. Бусад засварыг тоног төхөөрөмжийг худалдан авсан мэргэжлийн газруудаар болон засварын газрын дагнасан байгууллагаар гүйцэтгүүлэхээр төсөлд тусгав.

1.4.3. Уурхайн барилга байгууламж

Уурхайд нийт 25 хүн ажиллана. Нийт ажиллах хүчний ихэнх хэсгийг Улаанбаатар хот болон орон нутгаас бүрдүүлэх чиглэлийг барина. Уурхай ба боловсруулах цех нь жижиг бүтэцтэй улирлын чанартай, 1 ээлжээр ажиллах учир уурхай дээр ажиллагсдыг хооллох, түр амрах зориулалттай овор бага контейнер хаус баригдах ба тусгайлсан дулаан хангамж шаардлагагүй юм.

1.4.4. Цахилгаан хангамж

“Ширээ Уул-2” гөлтгөний ил уурхай дээр 75кВт-ын хүчин чадалтай PE800x1800 маркийн хацарт бутлуур 1 ширхэг, 7,5 кВт-ын хүчин чадалтай шигшүүр 1 ширхэг, 5кВт-ын хүчин чадалтай (GZD 800x1800 маркийн тэжээгүүр 1 ширхэг, 5кВт-ын хүчин чадалтай B1000 маркийн конвейер 2 ширхэг, гэрэлтүүлэг зэрэг цахилгаан хэрэглэгчид ажиллах бөгөөд тэдгээр нь 0,4кВ-ын цахилгаан эрчим хүчээр хангагдах шаардлагатай. Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг дизель генератор (YAMAHA65kw) ажиллуулан цахилгаан эрчим хүчээр хангахаар тусгав.

2023 онд хийгдэх ажлын хэмжээ

- Энэхүү 2022 онд манай уурхай нь 97.8 мян м3 гөлтгөнө агуулсан давхарга олборлож 90.1 мян м3 хөрс хуулж нийт 108.1 мян м3 (90.1 мян м3 x 1.2) сийрэгжсэн хөрсийг гадаад болон дотоод овоолгод хураана. Бүтээгдэхүүн гаргалт 90.0 мян.тн байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Уур амьсгалын үзүүлэлтүүд

Дундговь аймгийн хувьд газрын гадаргын хотгор гүдгэрийн ялгаа төдийлэн их биш учраас аймгийн хэмжээгээр уур амьсгалын нөхцөл онцгой ялгардаггүй, эх газрын эрс тэс уур амьсгалтай. Намрын эхний гэнэтийн хүйтрэлт 10-р сарын дунд 10 хоногт тохиолдох ба зарим үед 9-р сарын дунд буюу эхний 10 хоногт болдог байна. Хүйтрэлгүй хоногийн тоо 125-135 хоногт үргэлжилдэг. Цаг уурын сүүлийн арван жилийн ажиглалтаар тус сумын нутаг нь нилээн дулаан, 10°C-ээс дээш 141 хоног үргэлжлэх бөгөөд хамгийн дулаан 7-р сарын дундаж температур +22,4°C, хамгийн хүйтэн 1-р сарын дундаж температур -16,2°C байна. Салхины урсгалын чиглэл нь ихэвчлэн баруун хойноосоо буюу хойноосоо салхилах ба салхины дундаж хурд 4,1м/сек, салхины хүч хавар 4 ба 5-р сард дээд хэмжээндээ хүрнэ. Сүүлийн жилүүдийн ажиглалтаас үзэхэд өвөлдөө цасан бүрхүүл нэлээд нимгэн байдаг учир их хүйтэрч хөрсний хөлдөлт гүн байдаг. Жилийн бүх тунадасны 93,6 хувь нь дулааны улиралд унадаг байна.

2.2. Газрын гадарга, хэвлийн тогтоц, онцлог

2.2.1. Геологийн тогтоц, давхрага зүй

Ширээ уул-2 ордын талбайд дээд-дунд олигоцены настай ногоон, улаан хүрэн, хүрэн бор шавар, элсэн чулуу, хөрсөн чулуу, элс, элсэнцэр, шавранцар ба гөлтгөнө тархалттай байна.

Ордын баруун, баруун хойт хэсгээр гөлтгөнө агуулсан цайвар ногоон өнгийн шавар газрын гадаргууд тааралдах ба гөлтгөнө нь конкрец буюу судал хэлбэрээр тогтсон байдаг. Мөн ордын төв болон баруун урд талаар газрын гадаргуугийн хамгийн өндөрлөг хэсэг, жижиг гүвээ толгодын энгэр оройн хэсэгт тогтсон ногоон болон улаан хүрэн шаврын гөлтгөнөөр баяжигдсан хэсэг нь “шапка” байдалтай 50x200 м, 100x300 м хэмжээтэй биетийг үүсгэн тогтсон байдаг. Зузаан нь 2,0 м хүрдэг. Энд гөлтгөнө нь жижиг-том мөхлөгтэй хагас тунгалаг, тунгалаг талстууд, цайвар ногоон өнгөтэй шороолог талстыг үүсгэн тогтжээ. 1993, 2015 оны эрэл хайгуулын ажлаар 15-30 м хүртэл өрөмдөхөд гөлтгөнө нь төмрийн усан ислээр баяжигдаж улаан хүрэн өнгөтэй болсон шаврын дотор гол төлөв конкрец байдалтай ялгарсан байна. Гөлтгөний конкрец нь 10-20 см /хааяа 30 см/хэмжээтэй, дугуйвтар гонзгой хэлбэртэй байдаг.

2.2.2. Гидрогеологи

Судалгааны талбайн районд тархсан газрын доорхи ус нь хөдөлгөөн болон хуримтлалын нөхцөлөөрөө давхрагын, ан цавын гэсэн хоёр төрөлд ялгагдана. Давхаргын ус нь ихэвчлэн дөрөвдөгчийн сэвсгэр хурдсанд агуулагдах ба ус агуулагч хурдас нь хайрга, хайрганцар, элс, элсэнцэр юм. Ус агуулагч хурдасны гүн 5-20 м заримдаа 5-37 м хүрэх ба уст үеийн зузаан 1 м хүрнэ. Ордоос баруун урагш 5 км-т орших Цагаан усны уурхайн худаг нь давхаргын ус бөгөөд химийн найрлагаараа гидрокарбонат натрийн ангилалд багтах ба цэнгэгдүү, зөөлөвтөр ус боловч бохирдолт нь ундны усны стандартаас их байна. Ан цавын ус нь дунд рифейн настай хувирмал чулуулаг, дунд девон, доод пермийн настай гүний чулуулаг тархсан талбайд ан цав, тектоник хагарлыг дамжин үүссэн байдаг. Талбайгаас зүүн хойш 13 км-т хуучин өрөмдсөн цооногоос ус даралтаар байнга урсан гарч байдаг ба энэ нь ан цавын ус бөгөөд олон жилийн турш хүн, малын ундны хэрэгцээг хангаж байна.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

БОННУ-нд тусгагдсанаар уг гөлтгөний ордыг ашиглаж дуусах үед уурхайн 38.31 га талбайн геологийн тогтоц, үржил шимт хөрс хуулагдаж, ургамлын нөмрөгийн бүрэн байдал, органик нэгдлийн хуримтлал сарнин устаж, хөрс ургамлын үе давхаргад тархан төлжиж амьдарч байсан бичил организм, шавьж хорхой, сээр нуруугүйтэн болон бусад амьтдын амьдрах орчин өөрчлөгдөж, амьдралын хэвийн тогтолцоо тодорхой хэмжээгээр алдагдана. Үүний нөлөөгөөр биогеоценозын тэнцвэрт байдал алдагдана.

- Уурхайн үйл ажиллагааны явцад нэлээд хэмжээний тоос шороо босч ил гарсан гадаргуугаас салхиар зөөгдөн ойр хавийн ялангуяа салхины давамгайлах чиглэлийн дагуу хөрс ургамлыг дарж байгалийн өнгө төрхийг түр муутгах, ойролцоох айлууд, ургамал, амьтны хэвийн амьдрах нөхцөлийг алдагдуулна гэж үзсэн байна.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Ширээ уул-2 гөлтгөнийн ордын ил уурхайд байгаль орчныг хамгаалах талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Уурхайн техникийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд гадаад болон дотоод овоолгыг хийж гүйцэтгэх, хайгуулын ажлын үед гаргасан (үүсгэсэн) суваг, шуудуу, нүхнүүдийг дарж булаах.
- Шатахуун, тослох материалаар хөрс бохирдуулах, олон салаа зам гаргахаас сэргийлэхийн тулд тээврийн хэрэгслийн зогсоол, завсрын талбайг тохижуулах.
- Хуурай хог хаягдлын зориулалтын цэгт хуримтлуулах нөхцөлийг хангах.
- Уурхайн үйл ажиллагааны явцад гарсан хоёрдогч түүхий эдийн хог хаягдлыг тусгай цэгт цуглуулж төвлөрсөн цэгт тушаах.
- Усны хэрэглээнд хяналт тавьж, усыг гэрээний үндсэн дээр ашиглах, шинэ усны эх үүсвэр бий болгоход анхаарч ажиллах.
- Уурхайн ашиглалтын үед гал гарч болзошгүй хэсгүүдэд гал унтраах анхан -шатны багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тоноглох.
- Ажлын байр, зам талбайд ХХАА-ны ба замын хөдөлгөөний дүрмийн тэмдэг, самбар булан, дохио, санамжуудыг хийж тавих.
- Гэнэтийн үерийн ус, галын аюулаас хамгаалах зориулалтаар баяжуулалтын тоног төхөөрөмжүүд болон ашиглаж буй талбайг тойруулан суваг татах далан байгуулах.
- Тэр бум мод тарих хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд компаний оролцоог хангаж ажиллах.

БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1.. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 9 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах.арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг г/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
АГААР ОРЧИН						
Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгааны хэмжээ, норм.горимыг сар, улирлаар оновчтой тогтоох,	Уурхайн талбайн хэмжээгээр	-	-	Төсөл хэрэгжих хугацаанд	Агаарын тухай хууль, MNS 4585:2007 Агаарын чанар.Техникийн ерөнхий шаардлага Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2- 3- 16:1998 MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ
	Ажлын байрны агаарын чанарыг сайжруулах арга хэмжээ тогтмол авч байх;	Үйлдвэрийн байранд	-	-	2023 он	
	Уурхайн ухалт, ачилт буулгалтын цагийг хоногийн салхины горимтой уялдуулан зохион байгуулах	Үйл ажиллагааны турш	ҮАЗардалд	-	Төсөл хэрэгжих хугацаанд	
	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарахутааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах	Үйл ажиллагааны турш	-	-	Төсөл хэрэгжих хугацаанд	

))

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Ширээ уул-2 орд (баяжуулж боловсруулах үйлдвэр)-ыг ашиглах явцад 2022 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Агаарын бохирдлын улмаас уурхай дахь ажлын нөхцөл, ажилчид болон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх	Уурхайн карьер доторх болон түүнээс гарч буй замуудад хайргачулуу дэвсэх, замыг хусаж байх	Үйл ажиллагааны турш	ҮАЗ-д	ҮАЗ-д	Төсөл хэрэгжих хугацаанд	
	Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах,	Ажиллах хугацаанд бүх хүнд	500.0	500.0	Жил бүр	
НИЙТ ДҮН				500.0		
УСАН ОРЧИН						
Ус ашиглах	Ахуйн болон ногоон байгууламж, тоосжилт дарах ус хэрэглээний хэмжээг нарийвчлан тооцох	Үйл ажиллагааны турш	•	-	-	MNS 13.060.50 Усны чанарын стандарт Усны тухай хууль 3Г-ын 2013 оны 326 дугаар тогтоолын хавсралт -Ус ашигласаны төлбөрийн хувьхэмжээ/ Газар доорх усыг бохирдлоос хамгаалах: MNS 3342:1982 БО, ЭМНХ-ын сайдын 1997 оны 143А, 352/А тоот хамтарсан тушаалын 2.3.5 хавсралт,
	Ус ашиглалтын зөвшөөрөл авах, гэрээг холбогдох орон нутгийн болон бусад холбогдох байгууллагатай хийж баталгаажуулах, төлбөрийг цаг тухай бүр төсвийн дансанд оруулах	Уурхай ажиллах нийт хугацаанд	Ашиглах усны хэмжээгээр	-	-	

Ахуйн хаягдал, шатах, тослох материал ба бусад хаягдлаасбага гүний уст давхарга болонхөрс ургамал бохирдох	Шатах, тослох материалын хаягдал, асгаралт гаргахгүй байх;	Үйл ажиллагааны турш	300,0	300,0	Жил бүр ашиглалтын хэмжээгээр Төсөл хэрэгжих хугацаанд	
	Бороо цас үерийн ус цуглуулах санбайгуулах, тоосжилт дарах зорилгоор хэрэглэх	Боломжит газрыг сонгох ажиллах хугацаанд	300,0	300,0	Төсөл хэрэгжих хугацаанд	
Нийт дүн				600.0		
ХӨРС, УРГАМЛАН БҮРХЭВЧ						
Хөрс элэгдэл эвдрэлд орж үржил шим, чийгбуурах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Ил уурхай, овоолго байгуулах талбайн үржил шимт хөрсийг хуулж, 5м-ээс өндөргүй овоолон хадгалах	Үйл ажиллагааны турш		ҮАЗарда лд	Төсөл хэрэгжих хугацаанд	MNS3307:1991, MNS3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээгтодорхойолох арга, MNS5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5915:2008
	Уурхайн дотоод гадаад тээвэрлэлтийн замыг хайрганхучилттай болгох	Үйл ажиллагааны турш	-	-	Төсөл хэрэгжих хугацаанд	
Тээвэрлэлтийн н улмаас хөрсний эвдрэл үүсэх	Тогтсон маршрутын дагуу тээвэрлэлт хийх	Төслийн талбайд	-	-	Тухай бүрд	
	Замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулахсамбар хийж байрлуулах,	Төслийн талбайд	300.0	300.0		
	Олон салаа зам гарахаас сэргийлж тэмдэг,	Төслийн талбайд	200.0	200.0	Төслийн эхэнд	

	тэмдэглэгээ байрлуулах				
Ахуйн хаягдал, шатах, тослох материал	Шатах, тослох материалыг зориулалтын саванд хадгалах.орчинд асгарч алдагдахаас сэргийлэх,	Үйл ажиллагааны турш	-	300.0	-
	Хог хаягдлыг тухай бүрт нь ангилан зайлуулах арга хэмжээ авах	Төслийн талбайд		500.0	Тухай бүрд
Нийт дүн				1 300.0	
Нийт зардал			2 400.0		

5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Энэхүү 2023 оны хэмжээнд биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй бөгөөд нийт 1.0 га талбайд гадаад болон дотоод овоолго хийх замаар техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөлөө. Дээрх ажлыг гүйцэтгэхдээ үйл ажиллагааны зардалаар хийнэ.

Хүснэгт 10 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Техникийн нөхөн сэргээлт	Дотоод овоолго	га	0,5	ҮАЗ-аар гүйцэтгэх		Төлөвлөгөөт 2023 онд	MNS 5916-2008 MNS 5917-2008 MNS 5918-2008
		Гадаад овоолго (шимт хөрсний овоолгыг тусад нь хийх)	га	0,5	ҮАЗ-аар гүйцэтгэх			
Нийт						2 000.0 + ҮАЗ		

5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	дх зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж
1	Аюул заналыг бууруулах арга хэмжээ	Тэр бум мод тарих хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг дэмжиж ажиллах сумтай хамтран ажиллаж буй мэргэжлийн байгууллагыг дэмжиж ажиллах	2 удаа	ш	500	1 600.0	
2		Тэр бум мод тарих хөдөлгөөний хүрээнд уурхайн кемп орчмыг зүлэгжүүлэх, мод тарих	2 удаа				
Дүн						1 600.0	

5.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Ашигт малтмалын талбай болон түүний нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэлт хийх айл өрх байхгүй тул төлөвлөгөөнд тусгагдаагүй болно.

5.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Монгол улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрхзүйн хүрээнд ажиллана. Цаашид ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйлс илэрсэн тохиолдолд уулын ажлыг нэн даруй зогсоож, хуулийн хүрээнд авбал зохих арга хэмжээг авч ажиллана.

5.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Технологийн онцлогоос хамааран тусгайлан химийн бодис ашиглагдахгүй тул 2023 оны БОМТөлөвлөгөөнд тусгагдаагүй болно. Харин машин механизмд хэрэглэх түлш, шатах тослох материалаас үүсэх эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгасан болно.

Хүснэгт 12 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугамсүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Ил уурхайд, бутлахцех, барилга байгууламж техник тоног төхөөрөмжид	Тогтмол		ҮАЗ	Өдөр бүр, тогтмол уурхайн байгаль Орчны мэргэжилтэн хариуцна/	Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1 Ил уурхайн аюулгүй ажиллагааны ДҮРЭМ
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Нийт ажиллах хугацаанд уурхайн бүх ажилчдад	Улирал бүр		500.0	Сургалтыг улирал бүрт 1 удаа	
Байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Осол эрсдэл үүссэн үед устга арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Үйл ажиллагааны турш	1		ҮАЗ	Жил бүр	
Хүний эрүүл мэндэд нөлөөлөл үүсэх	Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинэн				2 500.0		MNS 4990:2000

	гутал, резинэн бээлий, хамгаалалтын нүдний шил, маск) хангах						
Нийт зардал							3 000.0

5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Бид энэхүү 2023 онд хог хаягдлын менежментийн талаар МУ-ын УИХ-аас батлан гаргасан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, журмуудыг баримтлан ажиллана.

Хүснэгт 13 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Тоо хэмжээ э	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах хууль, журам, стандарт
Ахуйн гаралтай хог хаягдал	Сумын төвд хоёрдогч түүхий эд авах цэгүүдэд төслөөс гарсан дугуй, автомашины сэлбэг, төмрийн хаягдал, хуванцар сав, шил, лааз зэргийг тушаах замаар эх үүсвэрээс зайлуулж ажиллах	Төслийн хэмжээнд			Гарсан хэмжээгээр	400.0	ҮА-ны туршид	Хог хаягдлын тухай хууль 9- р зүйл. МЫ8 5344:2011 Хог хаягдлын тээвэрлэлт, ангилал, ерөнхий шаардлага Хог хаягдал, ангилан ялгах, кодчилох журам
	АМТЗ-ийн талбай болон уурхайн тосгон орчимд хийсч тархсан болон үүссэн хог хаягдлыг тогтмол хугацаагаар цэвэрлэж хэвших	Төслийн хэмжээнд	кг	Үүссэн хэмжээ гээр	ҮАЗардал	ҮАЗардал		
	Дэлгэрхангай СЗД-тай хог хаягдлын гэрээг хийх, төлбөрийг төлж байх	Төслийн хэмжээнд	удаа	1	ҮАЗардал	ҮАЗардал	Оны эхэнд гэрээ байгуулах, цаг тухай бүрт нь төлөх	
	Ахуйн гаралтай хатуу хог хаягдлыг уурхайн түр хогийн цэгт төвлөрүүлэн хуримтлуулах	Төслийн хэмжээнд	кг	Гарсан хэмжээ гээр	-	-		

Аюултай хог хаягдал	Төсөлд ашиглагдаж буй тээврийн хэрэгсэлүүдэд ашиглагдсан аккумулятор, тос, тосны шүүр, фильтр зэргийг тусгайлан ангилж, агуулахад хадгалах ба тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад нийлүүлэх замаар эх үүсвэр дээрээс нь аюулгүйгээр зайлуулах	Төслийн хүрээнд	Удаа	Үүссэн хэмжээ гээр	ҮАЗардал	ҮАЗардал	ҮА-ны туршид	
Дүн						400.0		

5.8. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Төсөл хэрэгжүүлэгч “Түмэн төл” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч "Түмэн тал " ХХК нутаг дэвсгэрийн сум, багийн иргэдийн нийтийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ.

Мөн ОХШХөтөлбөрийн хүрээнд хөрсөн бүрхэвч, уст цэг, агаар орчин болон ургамлан нөмрөг зэргийн бохирдлын дээжлэлт, хэмжилтүүдийг хийхдээ уурхайн ойролцоо амьдарч буй өрхүүдийг төлөөлүүлэн 1-ээс доошгүй хүнийг байлцуулан гүйцэтгэж ажиллана.

Хүснэгт 14 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Нийт зардал мян.төг	Баримтлах стандарт ба арга, аргачлал	Дээд ДООД хязгаар
АГААРЫН ЧАНАР								

1	Агаар дахь тоосжилтын хяналт: Нийт тоос (TSP), PM2.5, PM10 Тоосны уналт	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 2 цэг сонгох зонхилох салхины доод ба дээд талд	Улирал тутамд 1 Удаа	Тоосжилтын хяналтын явуулах мониторингий н 2 цэгт	20.0	80.0	MNS 4585:2007 MNS:3384:1982 MNS:4048:1988	PM2.5-0.05 мг/м3 PM10-0.1мг/м3
	Дуу шуугиан, чичиргээ	Хүнд даацын машины тээврийн зам, бутлуур цех үйлдвэрийн тоног төхөөрөмжийн орчим 2 цэгт	Улирал тутамд 1 Удаа	2 цэгт	20.0	80.0	MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй жиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 180 226:2003 Дуу чимээ-хэвийн норм.түвшиний хэмжээ	ЗДХ
ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УС								
2	Гадаргын болон газрын доорх усны чанар: Гол ионы найрлага : Усны түвшин, рН, өнгө, булингаршил, хуурай үлдэгдэл, эрдэсжилт, нийт хатуулаг	Унд ахуйн усыг хангаж буй гүний худаг,	Улирал тутамд 1 Удаа	1 цэгдээр дээжлэлт хийж шинжлэх	30.0	120.0	MNS 3934:1986- ундны болон үйлдвэрлэлийн хэрэгцээт усны химийн шинжилгээ болон дээж авах, хадгалах; MNS (180) 5667- 5:2001- усны чанар- дээжлэлт	здх
	Усны түвшин усны ундарга нөөц	Ашиглалтын худагийн ойролцоох	Улирал тутамд 1 удаа	Нийт 2 цэг дээр түвшний хэмжилт хийх	20.0	80.0		-

		малчдын худагууд хяналтын цооног					MNS 900-2010 MNS 6148:2010 MNS 4586 : 1998	
ХӨРСӨН БҮРХЭВЧ								
3	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэгт	Улирал тутамд 1 удаа	Төслийн талбайд 2 цэг сонгох	30.0	120.0	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга	ЗДХ
4	Нефть, нефтийн бүтээгдэхүүн, нүүрсустөрөгчид, хүнд металлын агууламж микробиологийн үзүүлэлт	- Шатахуун ачих, буулгах, машин механизмыг шатахуунаар цэнэглэх талбай, агуулах орчимд - Хог хаягдал бохирын цэгийн орчимд	Улирал тутамд 1 удаа	Мониторингий н 2 ш тогтмол цэгт	30.0	120.0		ЗДХ

2023 онд хийгдэх ОХШХөтөлбөрийн зардал	600.0		
---	--------------	--	--

5.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 15 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ба зардал

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
Байгаль орчны асуудлыг удирдлагын түвшний 1 ажилтанд хариуцуулж, хяналт тавин ажиллах;	ҮАЗ	2023 онд	Уурхайн дарга	
Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	ХАБЭАЗ	2023 онд улирал бүр	Хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан	
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулан асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн удирдлагуудад танилцуулан батлуулж ажиллах ба хийгдсэн ажлуудыг тайлагнаж байх		2023 онд сүүлийн улиралд	Уурхайн дарга	
Сум, багийн удирдлага, ИТХ-тай хамтран ажиллах		2023 онд	Уурхайн дарга	
Нийт	ҮАЗардалаар гүйцэтгэх			

5.10. Тухайн жилийн БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

Хүснэгт 16 БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
Дундговь аймгийн БОАЖГ азар	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, тайлан хэлбэрээр хүргүүлэн тайлагнана.	БОМТөлөвлөгөөний хэрэгжилт	2023 оны 11 дүгээр сард багтаан	ҮАЗ	Компаний захирал болон уурхайн дарга	Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлнэ.
Бүх шатны Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч нар	Төлөвлөгөөт онд хийгдэж буй ажлуудыг АМТЗ-ийн талбай дээр нь хянуулан шалгуулж ажиллах	Тухайн онд хийгдэж буй ажлуудтай холбогдолтойг оор	Төсөл хэрэгжиж буй талбай дээр шалгалтаар очсон тухай бүрт	ҮАЗ	Уурхайн дарга	Уурхайн талбай дээр
Асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болох БОАЖЯ-ны ХБОБНУГазар	БОМТ-ий биелэлтийн тайланг А-618 тоот журмын дагуу боловсруулан хүргүүлж, хянуулан батлуулах	БОМТөлөвлөгөөний хэрэгжилт	Төлөвлөгөөнт 2023 оны 12 дугаар сард багтаах	ҮАЗ	Компаний захирал болон уурхайн дарга	Багийн төв дээр
Нийт				ҮАЗ		

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал
Хүснэгт 17 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Арга хэмжээ	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2400.0+ ҮАЗ
2	Нөхөн сэргээлт хийх,	2000.0+ ҮАЗ
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө	1600.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3000.0+ ҮАЗ
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	400.0+ ҮАЗ
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	ҮАЗ
9	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	600.0
10	Тухайн жилийн БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	ҮАЗ
	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	10,000,000.0

Уг төслийн үйл ажиллагаандаа 2023 онд хэрэгжүүлэн ажиллах Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **10,000,000.0 мян.төг** болж байна.

УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

Хянасан огноо	
Хянасан мэргэжилтэнгүүдийн хувийн дугаар	
Дүгнэлт <ul style="list-style-type: none"> • Шийдвэрийн төсөл • Ололт, амжилттай тал • Дутагдалтай сул тал • Шаардлага 	

НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН этгээд, ТӨСЛИЙН ТУХАЙ товч мэдээлэл

- Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэн дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, багананд мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.
- Тухайн төсөлд хамаарахгүй хэсгийг “*хамааралгүй*” гэж бөглөх.
- 1.2.7 дах хаалтын дараах зориулалт гэдэгт уурхайн хаалтын дараа нөхөн сэргээсэн газрыг бэлчээр, газар тариалан, агуулах, олон нийтэд зориулсан үйлдвэр, үйлчилгээ гэх мэт тухайн газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулахаар төлөвлөж буй бол орон нутагтай урьдчилан тохиролцсон чиглэлийг оруулах.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1.	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	“Түмэнтал” ХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9019079096
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Гадаад худалдаа
	4. Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг	УБ хот, Чингэлтэй, 4-р хороо, Бага тойруу, 19байр 32 тоот Харилцах утас:99099048
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Ч.АЛТАНХУЯГ
	6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	tumenand@gmail.com
1.2	1. Төслийн нэр	“Ширээ-уул 2” нэртэй гөлтгөний ордыг ил уурхайн аргаар ашиглах
	2. Төслийн харъяаллын байршил	Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутаг дэвсгэрт Ширээ уул нэртэй газарт

3. Төслийн ангилал а. нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр гэх мэт б. ил уурхай, далд уурхай, шороон орд с. баяжуулах үйлдвэр	а. Гөлтгөнө б. Ил уурхай
4. Төсөл эхэлсэн огноо	
5. Төсөл хэрэгжих хугацаа	17 жил
5. Уурхайн хаалт эхлэх огноо	2016
7. Хаалтын дараах зориулалт	Хөдөө аж ахуй
3. ТЭЗҮ баталсан огноо	2015-12-16
Э. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	
Ю.Ажилчдын тоо	25
И.Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	Нийт 90.1 мян.м ³ хөрс хуулж, 97.8 мян.м ³ хүдэр олборлон, боловсруулна. Бүтээгдэхүүн гаргалт 90.0 мян.тн байна.
12.Тухайн төсөлд хамаарах дэд бүтэц • Замын урт, эхлэл, төгсгөлийн цэг, чиглэл • Шатахуун түгээгүүрийн тоо • Шатахууны агуулахын агууламжийн хэмжээ • Тэслэх, дэлбэлэх бодисын үйлдвэрийн хүчин чадал гэх мэт	• Уурхайн дотоод замын урт-О.бкм /уурхайн ам-уурхайн кемп/ • ШТМ-20тн-ы ёмкость

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэн хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах.
- Тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын нөөц, ТЭЗҮ баталсан хуулийн этгээд, дугаар, огноог оруулах
- Доорх хүснэгтийн 2.1.9, 2.1.10-т тусгагдсан холбогдох 7 материалын хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах багананд хавсралтын нэрийг оруулах.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
2.1	1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ Дугаар Хүчинтэй хугацаа Талбай	Дугаар: МУ-005356 Хүчинтэй хугацаа: 30 жил Талбай: 38.31 га

2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/ Дугаар Хүчинтэй хугацаа			Хамааралгүй
3. Химийн бодисын агуулахад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт			Хамааралгүй
4. Галын дүгнэлтийн огноо, дугаар			
5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд			2016.02.05 БОАЖЯамны Ерөнхий шинжээч
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд			2016 он БОАЖЯ-ны Ерөнхий шинжээч
7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо			Монгол-Ус төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019.03.25- ний 1/144 тоот ус ашиглуулах дүгнэлт
3. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо			2022-05-15
9. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтыг хавсаргах			Хавсаргав
Ю.Нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/	Тайлант онд гүйцэтгэсэн	0.1 га
		Төлөвлөгөөт онд гүйцэтгэх	1 га
	Биологийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/	Тайлант онд гүйцэтгэсэн	
		Төлөвлөгөөт онд гүйцэтгэх	-
11.ТХГН-ын тухай хууль, гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн заагтай давахцсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах			Хавсаргасан

ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3 дугаар

хавсралтанд тусгагдсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгад заасны дагуу химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсгээс холбогдох мэдээллийг доорх хүснэгтэд оруулах

- Тухайн жилд олон төрлийн химийн бодис ашиглахаар бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд химийн бодисын хор, аюул, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар хавсралтаар оруулж, доорх хүснэгтийн 3.1.1-д хавсралтын нэрийгдурдах (хэмжих нэгжийг дурдсан байх шаардлагатай)
- Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг бүрэн тусгасан тохиолдолд 3.1.2-ын мэдээлэл оруулах хэсэгт “хангалттай” гэсэн дүгнэлтийг оруулна.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хэсэг
3.1	1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /хэмжих нэгж/	Хамааралгүй
	2. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө Урьдчилан сэргийлэх арга хэмжээ - Эрсдлийн үед авах арга хэмжээ Учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ - Хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ	Хамааралгүй
3.2	1. Шатах тослох материалын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх 2. Тэслэх, дэлбэлэх бодисын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	1. Шатах тослох материал: 3 төрөл, ИО.Отонн 2. Хамааралгүй
